

**МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ
СОНГУУЛИЙН 24-Р ТОЙРОГТ 1НИСЭХ 1-Р БАГ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЮРАГИЙН ЖАВЗАНПАГМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**


2020.07.24

Мөрөн сүм

Уриа:

*Иргэн төөвтэй
Засаглалын төлөө*

- I. Улс төржилт, намчирхал, талцлаас ангид байж хувийн эрх ашигаа нийтийн эрх ашигаас илүүд үзсэн бүлэглэлийн нэгдэл дээр бий бослон шударга бус тогтолцооны эсрэг иргэдийн дуу хоолойг хүргэх, тэдгээрийг дэмжих, хамтран ажиллах
- II. Сум орон нутгийн хөгжилд чиглэсэн зорилтот бүлгийн амьжиргааг дэмжих аливаа жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн шалгаруулалт, зориулалтад хяналт тавьж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, хөдөлмөрийн настын иргэн бүрт хүртээмжтэй “иргэн бүр баялаг бүтээгч” зорилгыг дэвшүүлэн, эдийн засгийн өндөр өсөлт бүхий ажилтай, орлоготой иргэдийн төлөө тууштай ажиллах
- III. Төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаанд шударга иргэдийн төлөөлөл бүхий хяналтын бүлгийг тогтмол ажиллуулж, хөгжилд чиглэсэн, бодит байдалд нийцэхүйц шаардлагыг эрх бүхий төрийн дээд байгууллагад уламжилж ажиллах
- IV. Банкны хүү, татвар, санхүүгийн дарамт, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй нийтийг хамарсан өвчлөл, өрхийн ядуурал үүсч буй эрсдэл бүхий нөхцөл байдлыг судлан тогтоож, “өргүй, өвчингүй иргэн” зорилгыг дэвшүүлэн хууль тогтоомжийн таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх талаар иргэдтэйгээ хамтран ярилцаж, санал бодлыг нэлгэн хууль тогтоогч төрийн түшээдэд үламжлах
- V. “Хөгжсөн Хөвсгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, баг орон нутгийн иргэдэд нэн тэргүүний тулгамдаад буй асуудал болох үер усны аюулаас үүдэлтэй эрсдлээс сэргийлэхэд чиглэсэн инженерийн хийцтэй үерийн ус зайлуулах инженерийн байгууламж барих асуудалд холбогдох эрх бүхий төрийн байгууллага, албан хаагчидтай хамтарч ажиллах
- VI. Баг орон нутгийнхаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг судлан Эко сестимд суурлисан ногоон байгууламж бүхий 1000 мод тарих ажлыг иргэдийн оролцоотойгоор хийх ажлыг зохион байгуулах



**МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ**

Ю.ЖАВЗАНПАГМА

Утас: 95116938

А. Г. З. Дэг